



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/35/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас:70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-22
3. Аудитын тайлан.....	22-25
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	26-27
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	27

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар


**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалагт баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2022.02.11 № 28

төвийн _____ -ны № _____ т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэээр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилууулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бүрэгхангай сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар жилийн эцэст хөрөнгийн тооллогын комисс томилон ажилласан боловч бараа материалын тодруулга тайлангийн 119288886 төгрөгийн материалын эцсийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, материалын тооллого хийгдээгүй зөрчил илэрсэн нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12 дугаар зүйлийн 2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12 дугаар зүйлийн 2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө," гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийт зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын дүнгээс илүү илэрхийлэгдэж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


006020594

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>52,175,433.47</u>	<u>263,397,541.28</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	55,543,654.96
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	55,543,654.96
3121	Төгрөг	-	55,543,654.96
31211	Төрийн сангийн харилцах	-	28,973,634.96
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	26,570,020.00
33	АВЛАГА	-	88,565,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	88,565,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,175,433.47	119,288,886.32
351	Түүхий эд материал	18,744,860.90	72,127,149.85
35110	Тусгай зориулалттай материал	7,136,289.00	12,930,792.20
35130	Эм боох материал	11,608,571.90	59,196,357.65
354	Хангамжийн материал	31,960,572.57	45,691,736.47
35410	Бичиг хэргийн материал	-	330,050.00
35420	Аж ахуйн материал	25,203,245.27	32,998,445.27
35430	Сэлбэг хэрэгсэл	3,585,000.00	4,185,000.00
35450	Барилгын засварын материал	-	2,838,000.00
35460	Хүнсний материал	2,778,127.30	4,739,241.20
35470	Бусад хангамжийн материал	394,200.00	601,000.00
35600	Мал амьтад	1,470,000.00	1,470,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>380,426,687.93</u>	<u>472,888,142.57</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	380,426,687.93	472,888,142.57
392	Биет хөрөнгө	372,416,687.93	463,903,142.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	281,901,459.57	281,901,459.57

**Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

39202	Хуримтлагдсан элэгдэл	(27,630,080.94)	(38,189,255.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,034,656.00	67,034,656.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(33,154,932.62)	(42,805,923.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	95,700,038.16	204,964,059.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,113,082.65)	(52,736,132.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,349,117.30	38,904,564.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,532,410.29)	(7,107,764.81)
39209	Зам, гүүрийн байгууламж	15,677,803.20	15,677,803.20
39210	Хуримтлагдсан элэгдэл	(3,505,279.80)	(4,479,725.40)
39217	Ном	689,400.00	739,400.00
393	Биет бус хөрөнгө	8,010,000.00	8,985,000.00
39301	Програм хангамж	-	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(375,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,010,000.00	8,010,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>432,602,121.40</u>	<u>736,285,683.85</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>770,724.83</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	770,724.83
413	Өглөг	-	770,724.83
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	770,724.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>232,152,529.11</u>	<u>735,949,562.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	232,152,529.11	735,949,562.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,010,000.00	8,010,000.00
51101	Өмч: - төрийн	8,010,000.00	8,010,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	27,823,984.21	331,171,424.83
51210	Өмнөх үеийн үр дүн	27,823,984.21	27,823,984.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	303,347,440.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	196,318,544.90	196,318,544.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>232,152,529.11</u>	<u>736,720,286.85</u>

САНХҮҮ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	479,948,773.21	1,221,539,275.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,309,961.21	387,618,715.56
120	Нийтлэг татварын бус орлого	66,309,961.21	387,618,715.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,309,961.21	387,618,715.56
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	66,309,961.21	387,618,715.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	413,638,812.00	833,920,560.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	314,466,000.00	377,667,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	314,466,000.00	377,667,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,690,580.00	385,825,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,847,880.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,735,700.00	350,232,730.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	107,000.00	34,792,370.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,658,000.00	58,603,690.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,658,000.00	58,603,690.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	23,824,232.00	11,824,070.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,824,232.00	11,824,070.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	452,892,900.61	918,191,834.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,892,900.61	918,191,834.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	451,854,475.97	892,531,834.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,542,057.46	321,238,295.34
210101	Үндсэн цалин	245,936,252.78	158,513,108.94
210102	Нэмэгдэл	380,913.68	106,863,524.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,919,000.00

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210104	Урамшуулал	6,224,891.00	51,942,661.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,760,400.00	34,864,966.96
210201	Тэтгэврийн даатгал	21,687,872.58	25,050,488.25
210202	Тэтгэмжийн даатгал	2,549,808.77	2,475,762.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,023,047.02	1,957,089.99
210204	Ажилгүйдлийн даатгал	499,970.15	488,900.87
210205	Эрүүл мэндийн даатгал	4,999,701.48	4,892,725.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,716,073.00	55,260,700.00
210301	Гэрэл, цахилгаан	5,047,330.00	5,105,943.00
210302	Түлш, халаалт	50,163,340.00	49,984,605.00
210303	Цэвэр, бохир ус	505,403.00	170,152.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,623,663.60	28,375,336.57
210401	Бичиг хэрэг	2,065,820.00	2,190,850.00
210402	Тээвэр, шатахуун	10,179,120.00	11,765,176.57
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,116,800.00	1,282,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,012,000.00	3,324,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,000.00	379,060.00
210408	Бараа материал акталсны зардал	2,999,923.60	9,433,450.00
2105	Нормативт зардал	53,491,267.65	396,139,095.38
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,366,556.35	381,414,406.28
210502	Хоол, хүнс	4,124,711.30	14,196,689.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	528,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,357,800.00	3,823,990.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	258,900.00	151,400.00
210604	Урсгал засвар	3,098,900.00	3,672,590.00
2107	Томилолт, зочны зардал	1,400,000.00	2,088,180.00
210702	Дотоод албан томилолт	1,400,000.00	2,088,180.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	571,594.00	2,098,196.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	139,594.00	1,523,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	76,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210807	Газрын төлбөр	-	14,896.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,391,620.26	48,643,074.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,299,826.00	1,885,060.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,091,794.26	46,758,014.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,038,424.64	25,660,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	25,660,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	25,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	660,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,424.64	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,424.64	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	27,055,872.60	303,347,440.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,643,400.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	15,643,400.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(15,643,400.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	11,412,472.60	303,347,440.62

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	413,638,812.00	745,355,560.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	413,638,812.00	745,355,560.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	314,466,000.00	377,667,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	314,466,000.00	377,667,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,690,580.00	297,260,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,847,880.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,735,700.00	261,667,730.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	107,000.00	34,792,370.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,658,000.00	58,603,690.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,658,000.00	58,603,690.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	23,824,232.00	11,824,070.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,824,232.00	11,824,070.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	412,513,812.00	637,021,062.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412,513,812.00	637,021,062.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	411,475,387.36	611,361,062.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,542,057.46	320,467,570.51
210101	Үндсэн цалин	166,554,100.00	158,513,108.94
210102	Нэмэгдэл	69,362,700.00	106,863,524.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,919,000.00
210104	Урамшуулал	16,625,257.46	51,171,937.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,760,400.00	34,864,966.96

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	21,657,600.00	24,185,264.25
210202	Тэтгэмжийн даатгал	2,525,700.00	2,692,068.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,020,600.00	2,130,134.76
210204	Ажилгүйдлийн даатгал	525,300.00	532,162.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5,031,200.00	5,325,337.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,716,073.00	55,260,700.00
210301	Гэрэл, цахилгаан	5,047,330.00	5,105,943.00
210302	Түлш, халаалт	50,163,340.00	49,984,605.00
210303	Цэвэр, бохир ус	505,403.00	170,152.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,543,540.00	19,074,936.57
210401	Бичиг хэрэг	1,816,820.00	2,192,400.00
210402	Тээвэр, шатахуун	10,117,420.00	11,765,176.57
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,116,800.00	1,282,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,202,500.00	2,600,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,290,000.00	1,233,760.00
2105	Нормативт зардал	45,760,896.90	150,443,652.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,945,846.90	134,215,849.00
210502	Хоол, хүнс	3,979,050.00	10,095,803.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	836,000.00	6,132,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,353,800.00	24,477,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,411,900.00	17,505,860.00
210604	Урсгал засвар	2,941,900.00	6,971,990.00
2107	Томилолт, зочны зардал	1,400,000.00	2,088,180.00
210702	Дотоод албан томилолт	1,400,000.00	2,088,180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	633,294.00	2,098,196.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,294.00	1,523,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	450,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	76,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210807	Газрын төлбөр	-	14,896.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,765,326.00	2,585,010.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,765,326.00	2,585,010.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,038,424.64	25,660,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	25,660,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	25,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	660,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,424.64	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,424.64	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,125,000.00	108,334,497.96
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,125,000.00	52,356,240.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,125,000.00	52,356,240.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,125,000.00	52,356,240.00
223001	Бусад хөрөнгө	1,125,000.00	52,356,240.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,125,000.00)	(52,356,240.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	55,978,257.96
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	55,978,257.96

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-		-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,459,592.29	196,318,544.90	27,823,984.21	-	432,602,121.40
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	208,459,592.29	196,318,544.90	27,823,984.21	-	432,602,121.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,459,592.29	196,318,544.90	27,823,984.21	-	432,602,121.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	303,347,440.62	-	303,347,440.62
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,459,592.29	196,318,544.90	331,171,424.83	-	735,949,562.02

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	463748200.00	419121825.04

**Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

21	УРСГАЛ ЗАРДАЛ	463748200.00	413971825.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	462948200.00	413311825.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283422400.00	260384221.51
210101	Үндсэн цалин	176828700.00	158513108.94
210102	Нэмэгдэл	80082300.00	81846972.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5292000.00	3919000.00
210104	Урамшуулал	21219400.00	16105140.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38262100.00	34864966.96
210201	Тэтгэврийн даатгал	26925200.00	24185264.25
210202	Тэтгэмжийн даатгал	2834200.00	2692068.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2267400.00	2130134.76
210204	Ажилгүйдлийн даатгал	566800.00	532162.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5668500.00	5325337.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57639100.00	55260700.00
210301	Гэрэл, цахилгаан	5500000.00	5105943.00
210302	Түлш, халаалт	51439100.00	49984605.00
210303	Цэвэр, бохир ус	700000.00	170152.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	21203300.00	18297636.57
210401	Бичиг хэрэг	1760000.00	1727400.00
210402	Тээвэр, шатахуун	13945000.00	11564676.57
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,375,800.00	1,282,800.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,822,500.00	2,489,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	1,233,760.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	39,749,600.00	36,103,204.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,799,600.00	25,984,501.00
210502	Хоол, хүнс	7,940,000.00	7,238,703.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,010,000.00	2,880,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	2,463,890.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	470,900.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,992,990.00
2107	Томилолт, зочны зардал	1,700,000.00	1,254,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,700,000.00	1,254,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,673,000.00	2,098,196.00

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	1,523,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	882,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	219,500.00	76,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
210807	Газрын төлбөр	40,500.00	14,896.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,798,700.00	2,585,010.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,798,700.00	2,585,010.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
211	ХҮҮ	-	-
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	-
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр		
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	-
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		
212	ТАТААС	-	-
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	660,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	660,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	660,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,150,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,150,000.00
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө	-	5,150,000.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө		
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл		
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл		
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	463,856,800.00	450,480,870.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	377,667,700.00	377,667,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	377,667,700.00	377,667,700.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60,989,100.00	60,989,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	60,989,100.00	60,989,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,200,000.00	11,824,070.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		

**Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,200,000.00	11,824,070.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	-
122001	Хандив тусламж /дотоод/		
122002	Хандив тусламж /гадаад/	-	-
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		28,973,634.96
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-
610001	Төсвийн байгууллага		
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан		

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	270,690,080.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	223,483,840.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,483,840.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,517,952.00
210102	Нэмэгдэл	25,016,552.00
210104	Урамшуулал	35,501,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	777,300.00
210401	Бичиг хэрэг	465,000.00
210402	Тээвэр, шатахуун	200,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	111,800.00
2105	Нормативт зардал	114,340,448.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	108,231,348.00
210502	Хоол, хүнс	2,857,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,252,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,013,960.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,034,960.00
210604	Урсгал засвар	4,979,000.00
2107	Томилолт, зочны зардал	834,180.00
210702	Дотоод албан томилолт	834,180.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,206,240.00
2200	Дотоод эх үүсвэрээр	47,206,240.00
223001	Бусад хөрөнгө	47,206,240.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	297,260,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	297,260,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	261,667,730.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,792,370.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,570,020.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бүрэгхангай сумын ЭМТ нь “Сумын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанар, аюулгүй байдлыг хангаж үйлчлэх” гэсэн зорилго тавьж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагыг хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт хөрөнгийн 432.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бүрэгхангай сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна. Үүнд: Санхүү байдлын, Үр дүнгийн, Мөнгөн гүйлгээний, Өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Бүрэгхангай сумын ЭМТ нь 2021 онд улсын төсвөөс 437.8, ЭМДС-гаас 25.2 сая төгрөг буюу нийт 463.0 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тус сумын ЭМТ нь 2021 он улсын төсвөөс 377.7, орон нутгийн төсвөөс 60.9, ЭМДСангаас 11.8, нэмэлт дансаар 216.7, өөрийн үйл ажиллагааны орлогоос 34.8, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 0.8 буюу нийт 747.7 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 689.9 сая төгрөгийг зарцуулж, 2.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, мөнгөн гүйлгээний тайлангаар 55.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бүрэгхангай сумын ЭМТ нь 2021 онд нэмэлт дансаар нийт 270.7 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 244.1 сая төгрөгийг зарцуулж 26.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, нэмэлт дансаар ковид, дархлаажуулалтын 262.1 сая төгрөгийн санхүүжилт авч ажилчдын урамшуулалд 35.5, хоол хүнсэнд 2.5, эм эмнэлгийн хэрэгсэлд 108.2, урсгал зардалд 4.9, нэмэгдэл цалинд 25.0, бичиг хэргийн зардалд 0.5, үндсэн хөрөнгийн зардалд 51.1, багаж техник хэрэгсэлд 13.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Бүрэгхангай сумын ЭМТ нь ковид буюу цар тахалтай холбогдуулаад ЭМС-ийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалуудыг үндэслэн тэтгэмж урамшуулалын зардалд 35.5, нэмэгдэл цалингийн зардалд 25.5 сая төгрөгийг тус тус олгожээ.

Хандив тусламжаар ЭМЯ-наас 53.1, иргэдээс 4.2, сумын ЗДТГ-аас 1.7, сумын орон нутгийн хувийн хэвшлийн байгууллагаас 10.0, аймгийн ЭМГ-аас 17.7 сая төгрөгийн нийт 86.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, эм боох болон хамгаалах хэрэгслийн 294.4, хоол хүнсний 6.3 сая төгрөгийн бараа материалыг тус тус орлогод авч тайлагнажээ. Энэ жил ковид цар тахалтай холбогдуулан үндсэн хөрөнгийн орлого 22.5, бараа материалын орлого 56.2 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хэвтэн эмчлүүлсэн, дархлаажуулалтын 88.5 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тодруулга тайланд бүрэн тусгаж 0.3 сая төгрөгийн өглөгтэй тайлагнаж харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн дүнгээр тооцоо нийлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй 1.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулга хийх 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 09 тоот албан бичгийн дагуу санхүүгийн тайланд залруулга хийж баталгаажууллаа.

3.8 Аудитын гол асуудал

Тус сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 12 эрсдэлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэрэгжүүлсэн горим сорилоор бараа материалын тодруулга тайлангийн 119.3 сая төгрөгийн эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогоор баталгаажуулж ажиллаагүй, дотоод албан томилолтын илтгэх хуудсыг дэлгэрэнгүй болоод томилолтоор явсан хугацаагаар нь ажилласан тайланг бичээгүй, дутуу бичиж тайлагнасан зөрчлүүд илэрсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Үүний дагуу байгууллагын мэдээллийг шилэн дансанд бүрэн мэдээлсэн боловч 2021 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын батлагдсан төсвийн мэдээ, худалдан авах ажиллагааны, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөөний мэдээ зэрэг 5 мэдээг хугацаанд нь мэдээлээгүй хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа ч бараа материалын жилийн эцсийн үлдэгдлийг тооллого хийж баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 12.1."Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:,12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 1 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 64 тоот албан бичгээр хүргүүлж ажиллажээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанаржуулж, хуулийн хүрээнд хагас бүтэн жилээр хөрөнгө, материалын тооллогын үлдэгдлийг баталгаажуулан ажиллаж хэвших шаардлага үүсэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 121.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 119.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгч, 1.9 сая төгрөгийн 2 алдааг залруулж ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Орлого үр дүнгийн тайланд 0.6 сая төгрөгийн зардал дансыг, мөнгөн гүйлгээний тайланд 1.3 сая төгрөгийн хөрөнгийн зардал дансыг тус тус буруу илэрхийлсэнг НББ-ийн тухай 15 дугаар зүйлд заасны дагуу залруулга хийж баталгаажуулан ажиллалаа.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй болно.

4.3 Албан шаардлага

Тус сумын ЭМТ нь жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн гэх боловч бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийг тоолж баталгаажуулж ажиллаагүй, материалын тооллого хийгдээгүй зөрчил илэрсэн нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12 дугаар зүйлийн 2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12 дугаар зүйлийн 2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага бичлээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод албан томилолтын зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Дотоод албан томилолтын илтгэх хуудсыг дэлгэрэнгүй, томилолтын хугацаагаар тайланг бичээгүй, дутуу бичиж тайлагнасан нь хэд хоног ямар ажил хийгдсэн нь тодорхой бус байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Томилолтын илтгэх хуудсыг тодорхой бичиж НББ-ийн тухай хуулийн 13.1 дэх заалтыг мөрдлөгөө болгож ажиллах.

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд мэдээлэх 2021 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын батлагдсан төсвийн мэдээ, худалдан авах ажиллагааны, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөөний мэдээтэй холбоотой 5 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлэх мэдээлийг цаг хугацаанд нь хоцроохгүй мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		/сая/төгрөгөөр/ Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бүрэгхангай сумын ЭМТ	5	121.2	2	1.9	0	0	1	119.3	2	0

